



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/90/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
4	
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
5	
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа	12
4.2 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Аудитын гэрчилгээ



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

1022-02-14 № 134
танай _____-ны № _____-т

УЯНГА СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАЯРМАГНАЙ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Аудитин газар\баигууллагийн дотод баримт\A4

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	52,092,029.48	45,807,100.42
33	АВЛАГА	10,598,235.88	545,753.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,998,235.88	545,753.82
33102	НДШ-ийн авлага	25,200.00	545,753.82
33103	ХАОАТ-ын авлага	1,973,035.88	-
33500	Бусад авлага	8,600,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	8,600,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	41,493,793.60	45,261,346.60
35100	Түүхий эд материал	-	110,000.00
35130	Эм боох материал	-	110,000.00
35400	Хангамжийн материал	41,493,793.60	45,151,346.60
35410	Бичиг хэргийн материал	500,000.00	500,000.00
35420	Аж ахуйн материал	357,600.00	361,400.00
35450	Барилгын засварын материал	5,215,500.00	317,000.00
35460	Хүнсний материал	-	6,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	35,420,693.60	37,972,946.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	2,127,172,900.89	2,318,799,645.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,127,172,900.89	2,318,799,645.28
39200	Биет хөрөнгө	2,087,244,900.89	2,278,871,645.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,177,247,237.51	2,372,625,368.51
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(237,007,322.92)	(280,953,175.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,625,000.00	24,625,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(5,490,624.96)	(7,453,125.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	117,245,658.75	163,420,858.75
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(96,851,232.41)	(109,801,169.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,700,174.93	130,703,631.03
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(51,054,484.67)	(63,265,752.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,176,948.84	34,631,242.04
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(5,818,728.10)	(11,348,287.87)
39217	Номын фонд	23,472,273.92	25,687,054.88
39300	Биет бус хөрөнгө	39,928,000.00	39,928,000.00
39301	Програм хангамж	285,000.00	285,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(285,000.00)	(285,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,928,000.00	39,928,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,179,264,930.37	2,364,606,745.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	468,970.00	5,444,411.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	468,970.00	5,444,411.70
41300	Өглөг	468,970.00	5,444,411.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	5,141,441.70
41311	Цалингийн өглөг	0.00	0.00
41313	ХАОАТ-ын өглөг	-	5,141,441.70
41360	Бусад өглөг	468,970.00	302,970.00
41361	Байгууллагад төлөх өглөг	468,970.00	302,970.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,178,795,960.37	2,359,162,334.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,178,795,960.37	2,359,162,334.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,928,000.00	39,928,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,138,867,960.37	2,319,234,334.00
51210	Өмнөх үеийн үр дүн	2,138,867,960.37	2,138,867,960.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	180,366,373.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,179,264,930.37	2,364,606,745.70

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,276,122,201.84	1,430,239,505.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,349,201.84	260,683,114.26
1200	Нийтлэг татварын бус орлого	62,349,201.84	260,683,114.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,349,201.84	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,349,201.84	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	258,130,861.26
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,552,253.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,213,773,000.00	1,169,556,391.00
1310	Улсын төсвөөс	1,198,668,000.00	1,023,287,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,839,500.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,062,828,500.00	1,023,287,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,105,000.00	1,370,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	15,105,000.00	1,370,091.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	144,898,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	144,898,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,277,730,944.40	1,245,319,631.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,277,730,944.40	1,245,319,631.67
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,250,313,200.90	1,178,755,731.67
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	896,389,273.71	805,513,723.76
210101	Үндсэн цалин	600,641,873.71	571,015,823.76
210102	Нэмэгдэл	226,306,700.00	186,850,400.00
210104	Урамшуулал	69,440,700.00	47,647,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,453,500.00	130,523,500.00
210201	Тэтгэврийн даатгал	85,459,800.00	100,360,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,998,400.00	7,540,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,198,700.00	6,032,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,799,700.00	1,508,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,996,900.00	15,081,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,764,810.91	141,406,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,264,310.91	4,739,460.00
210302	Түлш, халаалт	121,000,500.00	132,811,200.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	3,856,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,606,810.00	7,504,465.00
210401	Бичиг хэрэг	2,626,150.00	2,968,855.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	849,800.00	509,400.00
210404	Ном, хэвлэл	633,110.00	474,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	354,700.00	245,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,443,050.00	1,606,100.00
2105	Нормативт зардал	3,032,950.00	1,776,316.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,832,950.00	1,521,616.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	254,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,355,600.00	8,390,500.00
210604	Урсгал засвар	2,355,600.00	8,390,500.00
2107	Томилолт, зочны зардал	492,000.00	1,059,500.00
210702	Дотоод албан томилолт	492,000.00	1,059,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	877,500.00	1,271,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	301,500.00	695,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,340,756.28	81,309,726.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	487,900.00	415,600.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,982,376.00	3,543,510.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	84,870,480.28	77,350,616.91

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,417,743.50	66,563,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,154,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,154,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	186,189.09	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	186,189.09	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,985,954.41	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,985,954.41	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,245,600.00	61,409,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,955,600.00	60,209,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,290,000.00	1,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,868,722.15	4,553,499.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(1,608,742.56)	184,919,873.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	17,868,722.15	4,553,499.96
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	17,868,722.15	4,553,499.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	17,868,722.15	4,553,499.96
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(19,477,464.71)	180,366,373.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,213,773,000.00	1,169,556,391.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,213,773,000.00	1,169,556,391.00
1310	Улсын төсвөөс	1,198,668,000.00	1,023,287,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,839,500.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,062,828,500.00	1,023,287,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,105,000.00	1,370,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	15,105,000.00	1,370,091.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	144,898,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	-	144,898,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,207,268,000.00	1,162,756,391.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,207,268,000.00	1,162,756,391.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,180,155,256.50	1,089,892,491.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	898,362,309.59	798,919,800.00
210101	Үндсэн цалин	602,614,909.59	564,421,900.00
210102	Нэмэгдэл	226,306,700.00	186,850,400.00
210104	Урамшуулал	69,440,700.00	47,647,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,478,700.00	130,523,500.00
210201	Тэтгэврийн даатгал	85,485,000.00	100,360,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,998,400.00	7,540,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,198,700.00	6,032,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,799,700.00	1,508,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,996,900.00	15,081,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,764,810.91	141,406,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,264,310.91	4,739,460.00
210302	Түлш, халаалт	121,000,500.00	132,811,200.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	3,856,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,581,210.00	7,215,075.00
210401	Бичиг хэрэг	1,389,600.00	1,372,375.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,400.00	821,400.00
210404	Ном, хэвлэл	885,110.00	892,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	817,300.00	642,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,774,800.00	1,785,700.00
2105	Нормативт зардал	1,860,600.00	1,533,316.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,220,500.00	878,616.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	640,100.00	654,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,888,500.00	3,492,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	5,888,500.00	3,492,000.00

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	492,000.00	1,059,500.00
210702	Дотоод албан томилолт	492,000.00	1,059,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,866,500.00	1,445,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,290,500.00	869,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,860,626.00	4,297,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,320,000.00	726,200.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,540,626.00	3,571,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,112,743.50	72,863,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,154,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,154,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	186,189.09	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	186,189.09	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,985,954.41	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,985,954.41	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,940,600.00	67,709,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,650,600.00	66,209,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,290,000.00	1,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-II)	6,505,000.00	6,800,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,505,000.00	6,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,505,000.00	6,800,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	6,505,000.00	6,800,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,505,000.00	6,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI-I-V)	(6,505,000.00)	(6,800,000.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бүүралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бүүралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	39,928,000.00	-	2,138,867,960.37	-	2,178,795,960.37
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,928,000.00	-	2,138,867,960.37	-	2,178,795,960.37
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бүүралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бүүралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	180,366,373.63	-	180,366,373.63
16	ҮЛДЭГДЭЛ	39,928,000.00	-	2,319,234,334.00	-	2,359,162,334.00

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлан он		Зөрүү	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувиар
11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		-	-	-	-
12	Татварын бус орлого	1,169,338,300.00	1,168,186,300.00	1,152,000.00	99.90
120	Нийтлэг татварын бус орлого	576,000.00	-	576,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	576,000.00	-	576,000.00	-
122	Тусламж, санхүүжилтийн орлого	144,898,800.00	144,898,800.00	-	100.00
122005	Төсвөөс санхүүжих	144,898,800.00	144,898,800.00	-	100.00
123	Татаас санхүүжилтийн орлого	1,023,863,500.00	1,023,287,500.00	576,000.00	99.94
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,023,863,500.00	1,023,287,500.00	576,000.00	99.94
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,168,762,300.00	1,168,186,300.00	576,000.00	99.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,168,762,300.00	1,163,032,300.00	5,730,000.00	99.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,052,400.00	1,095,322,400.00	5,730,000.00	99.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	804,649,800.00	798,919,800.00	5,730,000.00	99.28
210101	Үндсэн цалин	570,151,900.00	564,421,900.00	5,730,000.00	98.99
210102	Нэмэгдэл	186,850,400.00	186,850,400.00	-	100.00
210104	Урамшуулал	47,647,500.00	47,647,500.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,523,500.00	130,523,500.00	(0.00)	100.00
210201	Тэтгэврийн даатгал	100,360,200.00	100,360,200.00	(0.00)	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,540,800.00	7,540,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,032,700.00	6,032,700.00	0.00	99.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,508,200.00	1,508,200.00	(0.00)	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,081,600.00	15,081,600.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,406,800.00	141,406,800.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,140,600.00	4,739,460.00	2,401,140.00	66.37
210302	Түлш, халаалт	132,811,200.00	132,811,200.00	(0.00)	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,455,000.00	3,856,140.00	(2,401,140.00)	265.02
2104	Хангамж, бараа материалын зардал	6,330,800.00	6,330,800.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	988,100.00	988,100.00	(0.00)	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,700,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	821,400.00	821,400.00	0.00	99.99
210404	Ном, хэвлэл	892,800.00	892,800.00	(0.00)	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	642,800.00	642,800.00	0.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,285,700.00	1,285,700.00	(0.00)	100.00
2105	Нормативт зардал	1,047,500.00	1,047,500.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	392,800.00	392,800.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	654,700.00	654,700.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,292,000.00	10,292,000.00	-	100.00
210601	Багаж, техник хэрэгсэл	6,800,000.00	6,800,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,492,000.00	3,492,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,059,500.00	1,059,500.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,059,500.00	1,059,500.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,445,000.00	1,445,000.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	869,000.00	869,000.00	(0.00)	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,297,500.00	4,297,500.00	(0.00)	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	726,200.00	726,200.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,571,300.00	3,571,300.00	(0.00)	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,709,900.00	67,709,900.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,709,900.00	67,709,900.00	-	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,209,900.00	66,209,900.00	(0.00)	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	-	-

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлан он
11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,370,091.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,370,091.00
2104	Хангамж, бараа материалын зардал	884,275.00
210401	Бичиг хэрэг	384,275.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00
2105	Нормативт зардал	485,816.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	485,816.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,370,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,370,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	1,370,091.00
12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу дээр зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.01.26-наас 2022.02.11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.09-ний өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бага дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.”Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь “суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн чанартай боловсрол, тэгш боломж олгож эрүүл аж төрөх зөв дадал төлөвшлийг хэвшүүлэн, хүүхэд нэг бүрийн авьяас чадварыг хөгжүүлсэн, шинэ зууны шилдэг менежменттэй тэргүүний хамт олон болох нь бидний эрхэм зорилго” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,238.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 12.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Уянга сумын 2 дугаар сургуулийн 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 274.7 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 6.8 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 263.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, 4.8 сая төгрөгийг хөрөнгийг шилжүүлж авчээ. Харин 6.5 сая төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагаруу шилжүүлжээ. Тайлант онд 195.4 сая төгрөгийн сантехникийн их засвар хийгджээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 75.1 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр, 2.5 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 73.9 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд 0.5 сая төгрөгийн авлагатай, 5.4 сая төгрөгийн өглөгтэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 5.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 1,023.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 144.9 сая төгрөг, өөрийн орлого 0.6 сая төгрөг батлагдаж, 1,168.2 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс төсвөөс авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 1.4 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Уянга сумын 2 дугаар сургууль нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 199.0 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 199.0 сая төгрөгийн 148 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч ажиллалаа.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар цалингийн зардлаас хэмнэгдсэн 13.5 сая төгрөгийг ахмадын сан дансанд төвлөрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Актын төлбөрийг бүрэн барагдуулсан.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитын явцад үндсэн хөрөнгө дутуу бүртгэсэн 195.4 сая, өглөг дутуу бүртгэсэн 5.1 сая, цалингийн зардлыг 21.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зэрэг алдаануудыг залруулж санхүүгийн үр өгөөжөөр тооцож, хүлээн зөвшөөрүүлсэн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 228.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 222.1 сая төгрөгийн алдааг залруулж, 6.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгуудыг хийсэн.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сантехникийн их засварын 195.4 сая төгрөгийг барилга байгууламжинд капиталжуулалт хийгээгүй байсныг хөрөнгөнд сайжруулалт хийсэн
- ХХОАТ-ын дутуу төлөлтийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байсныг 5.1 сая төгрөгөөр тусгуулсан
- Цалингийн зардлыг 21.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг залруулсан

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар.

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны сайтад 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх 1 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дугаар сарын 01-ний** өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Уянга сумын 2 дугаар сургууль	5	228.1	3	222.1			1	6.0	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар ӨБА/2022/90/УАСТА-ТМЗ/А/1560340/83 Арвайхээр

Уянга сумын 2 дугаар сургуулийн
Захирал Б.Баярмагнай танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үдийн цайны зардлаас хэмнэгдсэн 6000.0 мянган төгрөгөөр хүнсний материал нөөцөлсөн /т/х №160/ зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7.Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.” 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; “гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээр дурдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уянга сумын 2 дугаар сургуулийн захирал Б.Баярмагнай, нягтлан бодогч Б.Энхбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **О.БАТЖАРГАЛ**
АХЛАХ АУДИТОР **Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ**

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маяг
Аудитын код: ЭВА-2022/443/НА-СТА-ТШЗ


№	Ажил гүйцээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харюу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Нийт зардал	Үдийн цайны зардлыг 100 хувь шалгахад үдийн цайны зардалд зарцуулаагүй үлдсэн мөнгөөр 6000.0 мянган төгрөгийн материалыг нөөцөлж үлдэгдлээр тайланд тусгажээ.	6	Албан шаардлага өгөх	Санал байхгүй.	Төсвийн тухай хуулийн 7.7.Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ. 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Баярмагнай, Б.Энхбат
2	Шилэн дансны горим	Мөнгөн орлого зарлага болон бусад мэдээллийг Шилэн дансны сайтад байршуулсан мэдээлэлтэй тулгахад 148 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	0	Зөвлөмж өгөх	Санал байхгүй.	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шүүрхай мэдээлдэг байх;	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Баярмагнай, Б.Энхбат

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.ГАНСҮХ

О.БАЛЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

УЯНГА СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ХАШИРАГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАЯРМАГНАЙ

Б.ЭНХБАТ

